



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

# **СТАТИСТИКИЙН МЭДЭЭ**

## **III дугаар улирал**

Агуулга

1. Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт.....	3
2. Авто тээвэр.....	4
3. Төмөр замын тээвэр.....	4
4. Агаарын тээвэр.....	6

## 1. БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ:

### Зорчигч:

Бүх төрлийн тээврийн зорчигч өмнөх оны мөн үеэс 2 дахин өслөө

Бүх төрлийн тээврээр 2022 оны эхний 9 сард 116.5 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 58.7 (2.0 дахин) сая хүнээр өссөн байна. Зорчигчдын тоо өсөхөд авто тээврээр зорчигчид 56.3 (97.8%) сая хүнээр өссөн нь гол нөлөөлжээ.

### Ачаа:

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2022 оны эхний 9 сард 39.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.1 (3.0%) сая тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд авто тээврээр тээсэн ачаа 37.8 хувиар өссөн нь гол нөлөөлжээ.

### Тээврийн орлого:

Бүх төрлийн тээврийн орлого 2022 оны эхний 9 сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 342.7 (33.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд агаарын тээврийн орлого 211.6 (2.8 дахин) тэрбум төгрөг, авто замын тээврийн орлого 204.8 (65.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Бүх төрлийн тээврийн орлого 2022 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 151.9 (33.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

### Хүснэгт 1. Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	2022* I-IX
Тээсэн ачаа, сая тонн	39.9	38.8	39.9
Зорчигчид, сая хүн	100	57.8	116.5
Тээврийн орлого, тэрбум төгрөг	1047.7	1027.2	1369.9

жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар /өссөн дүнгээр/

График 1. Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт



## 2. АВТО ТЭЭВЭР:

Авто тээврээр 2022 оны эхний 9 сард 20.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 5.7 (37.8%) сая тонноор өсжээ. Энэхүү өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 48.5 хувиар өссөн нь гол нөлөөлсөн.

Авто тээврээр 2022 оны эхний 9 сард давхардсан тоогоор 113.9 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 56.3 (97.8%) сая хүнээр өссөн байна. Энэхүү өсөлтөд Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 109.1 сая болж, өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Мөн авто тээврээр тээсэн ачаа 2022 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 5.6 (97.5%) сая тонноор, зорчигчид 18.5 (66.4%) сая хүнээр тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Авто тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	2022* I-IX
Тээсэн ачаа, сая тонн	17.8	15	20.6
Уул уурхайн бүтээгдэхүүн	15.2	13.4	19.9
Зорчигчид, сая хүн	98	57.6	113.9
Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчид	88.2	50.2	109.1
Тээврийн орлого, тэрбум төгрөг	350.4	312.6	517.4


жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар /өссөн дүнгээр/

Авто тээврийн салбарын орлого 2022 оны эхний 9 сард 517.4 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 204.8 (65.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн авто тээврийн орлого 2022 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 47.2 (25.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

## 3. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР:

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2022 оны эхний 9 сард 19.3 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 4.5 (19.0%) сая тонноор буурчээ.

График 2. Төмөр замын тээврээр тээсэн ачаа



Төмөр замын тээврээр тээсэн ачааны бууралтад экспортын ачаа 3.1 (34.7%) сая тонн, дотоод ачаа 806.3 (8.8%) мянган тонноор тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Харин төмөр замын тээврээр тээсэн ачаа 2022 оны 9 дүгээр сард 2.3 сая тонн болж, өмнөх сараас 64.1 (2.8%) мянган тонноор өссөн байна.

Энэхүү өсөлтөд нүүрс тээвэрлэлт өмнөх сараас 37.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Төмөр замаар 2022 оны эхний 9 сард тээсэн ачаа өмнөх оны мөн үеэс уул уурхайн бүтээгдэхүүн 3.2 (22.1%) сая тонн, барилгын материал 417.9 (17.2%) мянган тонн, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 54.9 (31.1%) мянган тонн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 54.5 (36.7%) мянган тонн, хар төмөр 46.9 (22.1%) мянган тонноор тус тус буурсан байна.

Хүснэгт 3. Төмөр замаар дотоод, гадаадад тээсэн ачааны эзлэх хувь


Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III	2022* I-III
Нийт хувь	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	82.5	80.4	79.9
Барилгын материал	10.6	13.4	14.2
Мод, модон материал	0.6	0.4	0.3
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.9	1.0	0.8
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	0.8	0.8	0.7
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.7	1.2	1.2
Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	0.1	0.2	0.1
Бусад	2.8	2,6	2,8

жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар

Цар тахлын нөхцөл байдлын улмаас өмнөх оны мөн үед төмөр замын зорчигч тээврийн үйл ажиллагааг хязгаарлагдмал байсан бол 2022 оны эхний 9 сард зорчигчид 1.9 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 1.8 (29.7 дахин) сая хүнээр өссөн байна. Төмөр замын тээврээр зорчигчдын 99.4 хувийг орон нутагт зорчих иргэд эзэлж байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2022 оны 9 дүгээр сард 232.1 (давхардсан тоо) мянга болж, өмнөх сараас 87.0 (27.3%) мянган хүнээр буурсан байна.

График 3. Төмөр замын тээврээр зорчигчид




Төмөр замын тээврийн орлого 2022 оны эхний 9 сард 521.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 73.6 (12.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэхүү бууралтад төмрийн хүдэр, барилгын материал, жонш, жоншны баяжмалын тээвэрлэлт буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 1.5 (2.2%) тэрбум төгрөгөөр буурч 66.0 тэрбум төгрөг болжээ..

#### 4. АГААРЫН ТЭЭВЭР

Агаарын тээврээр тээсэн ачаа 2022 оны эхний 9 сард 9414.7 тонн болж, өмнөх оны мөн үеэс 6,152.5 (2.9 дахин) мянган тонноор өссөн байна.


График 4. Агаарын тээврээр тээсэн ачаа /сараар, тонн/



Агаарын тээврээр 2022 оны эхний 9 сард дотоодод 13.9 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 1.3 (10.3%) тонноор өссөн байна. Мөн олон улсад тээсэн ачаа 9,401.3 тонн болж, өмнөх оны мөн үеэс 6151.7 (2.9 дахин) мянган тонноор өссөн байна

Агаарын тээврээр тээсэн ачаа 2022 оны 9 дүгээр сард 942.1 тонн болж, өмнөх сараас 31.9 (3.5%) тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд олон улсад тээсэн ачаа 31.8 (3.5%) тонноор өссөн нь голлон нөлөөлжээ

График 5. Агаарын тээврээр зорчигчид /сараар, мянган хүн/



Агаарын тээврээр зорчигчид 2022 оны эхний 9 сард 675.1 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оны мөн үеэс 560.5 (5.9 дахин) мянган хүнээр өссөн байна.

Агаарын тээврээр зорчигчид 2022 оны 9 дүгээр сард 106.8 мянга болж, өмнөх сараас 22.4 (17.4%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Сеул, Франкфурт, Алтай, Токио, Станбул, Бусан

чиглэлийн зорчигчид буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2022 оны эхний 9 сард 245.3 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 183.3 (4.0 дахин) мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Оюутолгой чиглэлийн зорчигчид 161.8 мянга, Тавантолгой чиглэлийн зорчигчид 7.1 мянга, Ховд чиглэлийн зорчигчид 5.6 мянга, Өлгий чиглэлийн зорчигчид 4.6 мянга, Улиастай чиглэлийн зорчигчид 3.0 мянган хүнээр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2022 оны эхний 9 сард 429.8 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 377.1 (8.2 дахин) мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Сөүл чиглэлийн зорчигчид 178.0 мянга, Станбул чиглэлийн зорчигчид 69.6 мянга, Франкфурт чиглэлийн зорчигчид 33.7 мянга, Токио чиглэлийн зорчигчид 29.0 мянга, Бусан чиглэлийн зорчигчид 12.0 мянга, Ханой чиглэлийн зорчигчид 7.0 мянга, Улаан-Үүд чиглэлийн зорчигчид 6.8 мянган хүнээр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2022 оны эхний 9 сард 331.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 211.6 (2.8 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна. Харин агаарын тээврийн орлого 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 20.1 (27.0%) тэрбум төгрөгөөр буурч, 54.3 тэрбум төгрөг болжээ.

--oOo--